*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ САНГААГИЙН ОТГОНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “*Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.1. Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | 2024 байдлаар нийгмийн даатгалтай холбоотой Монгол улсын хууль -4, Засгийн газрын тогтоол-15,НД-ийн үндэсний зөвлөлийн тогтоол-6, НДЕГ-ын даргын тушаал-4, ОУ-ын хэлэлцээр 4, Сайдын тушаал-11-г холбогдох бусад дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| **Зорилт 2. “*Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*”** | | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.1.1 Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2023 онд 470,546.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, | Шинэчлэгдэн батлагдсан төсвийн нийт орлого 242,965.3 сая төгрөг, нийт зардал | 2024 оны 12 дугаар сарын 09-ны байдлаар Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 94.5 хувиар жигд ханган биелүүлэн ажилаллаа. | 2024.01.01-2024.12.31 | 94.5% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | | тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 319,140.0 сая төгрөг зарцуулсан. | 200,417.5 сая төгрөгийн төсвийг нарийвчилсан хуваарийн дагуу мөрдөж ажиллана. | Дээрх хугацаанд нийгмийн даатгалын санд 547 190.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 517 256. 46 сая төгрөгийн орлого төвлөрүүлж байна. | | |
| | | | | | 2024 оны онд газрын үйл ажиллагааны зардалд 2,497,162.7 мянган төгрөг батлагдаж 2,484,012.9 мянган төгрөгийн зардлыг ангилалын дагуу зарцуулсан. Үүнд: | | |
| 3. | Арга хэмжээ 2.1.2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1,810.2 сая төгрөг зарцуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1,176.0 сая төгрөгийг төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн дагуу мөрдөн ажиллана. | ➢ Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 1,874,693.4 мянган төгрөг батлагдсанаас 1,870,559.0 мянган төгрөг<br>➢ Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 245,086.5 мянган төгрөг зарцуулахаас 245,086.5 мянган төгрөгийг,<br>➢ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 58,446.4 мянган төгрөг батлагдсанаас 27,338.5 мянган төгрөгийг,<br>➢ Хангамж, бараа материалын зардалд 26,612.3 мянган төгрөг батлагдсанаас 26585,7 мянган төгрөгийг,<br>➢ Эд хогшил, урсгал засварын зардалд 46,287.6 мянган төгрөг зарцуулахаас 33,694.8 мянган төгрөгийг, | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ➢ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 8,429.9 мянган төгрөг зарцуулахаас 6,255.1 мянган төгрөгийг,<br>➢ Бараа үйлчилгээний бусад зардал 2,795.8 мянган төгрөг зарцуулахаас 253.0 мянган төгрөгийг<br>➢ Тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 62,111.8 мянган төгрөг зарцуулахаас 62,111.8 мянган төгрөгийг,<br>➢ Төлөөлөгчийн цалин урамшуулал 30,960.0 мянган төгрөг зарцуулхаас 18,927.0 , НДШ , ХХОАТ-д 4,207.4 мянган төгрөг зарцуулахаас 1,108.2 мянган төгрөгийг<br>➢ ЭХМК -ын цалин урамшуулал 82,736.7 мянган төгрөг зарцуулхаас , 68,137.9 мянган төгрөгийг , НДШ , ХХОАТ-т 13,342.2 мянган төгрөг зарцуулахаас 8,329.2 мянган төгрөгийг<br>➢ Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулалд 14,150.8 мянган төгрөг зарцуулахаас 9,324.3 мянган төгрөгийг зарцуулсан.<br>Нийт 13149,8 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 2.1.7. Бусад өглөг, авлагыг барагдуулах | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг 123.4 сая авлага 339.1 сая төгрөг санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 25 хувиас доошгүй барагдуулах.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | а) Нийгмийн даатгалын сангаас бусад өглөг нь оны эхний үлдэгдлээс 6.4 хувиар буурч 115.6 сая төгрөг, бусад авлага оны эхний үлдэгдлээс 1.36 хувиар буурч 334.5 сая төгрөг болсон байна.<br>б) 2024 оны тайлангаар манай байгууллага өр авлага байхгүй. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 5. | Арга хэмжээ 2.1.8. НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр төвлөрүүлэлтэд нийт 516 174.46 сая төгрөг бүрэн төвлөрүүлсэн байна. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 6. | Арга хэмжээ 2.1.9.Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад ..... төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу | а) Сар бүрийн 01ний өдөр 34606 тэтгэвэр авагч нарт нийт дундажаар сард 30 216.8 сая төгрөгний тэтгэврийг олгож хэвшсэн.<br>б) НДЕГ-ын даргын 2024 оны 10 сарын 22-ний өдрийн А/202 дугаар тушаалын дагуу тэтгэвэрт 364 471.9 сая төгрөг | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хугацаанд нь олгоно. | | 200,417.5 сая төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | тэтгэмжид 22 851,4 сая төгрөг, ҮОМШӨ-ний тэтгэвэр тэтгэмжинд 2 202,2 сая төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмжинд 18110,7 зарцуулж төгрөгийн ажилласан. | | |
| 7. | Арга хэмжээ 2.1.10.<br>Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Батлагдсан 1,913.3 сая төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 1810.2 сая төгрөг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | а) Төрийн хэмнэлтийн хуулиар байгууллагын үйл ажиллагааны зардалд 8,516.6 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.<br>а) Байгууллагын үйл ажиллагааны зардалд 2,162,662,5 мянган төгрөг батлагдаж 2,069,512.70 мянган төгрөгийн төсвийг зардлын ангилалын дагуу зарцуулсан.<br>в)Тус газар нь ажиллагсадтай холбоотой болон аж ахуйн нэгж байгууллагад өр авлага үүсгээгүй болно. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 8. | Арга хэмжээ 2.1.11.<br>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цагалбарын дагуу Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон нэгдсэн санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангуудыг тус тус боловсруулан хугацаанд нь | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | Нийслэлийн Нийгмийн даатгаын газарт тайлагнан ажилаллаа.<br><br>Мөн нийгмийн даатгалын сан, байгууллагын байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг тухай бүр гаргаж Нийслэлийн Нийгмийн даатгалын газарт тогтоосон хугацаанд хүргүүлэхээс гадна шилэн данс болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 9. | Арга хэмжээ 2.1.12.<br>Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023 оны А/92 дугаар тушаалаар баталсан *Өмч хөрөнгө , эд аж ахуйн тооллого явуулах журам* , БГД нийгмийн даатгалын газрын даргын А/06 тушаалыг үндэслэн тус газрын эд хөрөнгө , бараа материалын 2024 оны 2 удаагийн тооллогыг зохион байгуулж эд хөрөнгө , бараа материалын дутагдал байхгүй тайланг Нийгмийн даатгалын Ерөнхий газарт хүргүүлэхээр ажиллаж | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | , тайлагнаж ажиллана. | | хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах хугацаанд мэдээлэх; -Хагас жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна. | байна. 2023 оны өмч хамгааллын ажлаа өмч хамгааллын газарт шалгуулж онц дүгнэлт авлаа. | | |
| 10. | Арга хэмжээ 2.1.13.Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах. | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. | а)Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. | а)Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны 2023 оны санхүүгийн тайланд Аккаунт траст аудит ХХК-аар аудит хийлгэж “Зөрчилгүй” дүгнэлт авч ажиллалаа. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | б)Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | б) Түүнчлэн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмжөөр нийгмийн даатгалын сангийн болон бусад өглөг авлага үүсгэхгүй, шилэн дансны хууль, төсвийн хэмнэлтийг баримтлаж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлэн байгууллага, ажиллагсадтай холбоотой өглөг, авлагыг барагдуулж зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь хангаан 2024 оны санхүүгийн баримтаа аудитаар шалгуулан ажиллаж байна. | | |
| 11. | Арга хэмжээ 2.1.14. Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгылн ерөнхий газраас арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээний дагуу ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын олон төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжийг олгох, мөн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйлгээг шуурхай чирэгдэлгүй үйлчилгээний нэмэлт хураамжгүйгээр гүйцэтгэх зарчмыг баримтлан ажилласан. Мөн тэтгэвэр тэтгэмж олгох, сангийн дансны үлдэгдлийг төвлөрүүлэх зэрэг олон | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлуудыг гэрээнд дурьдсан журмын дагуу хийж гүйцэтгэв.<br><br>Нийгмийн даатгалын хэлтсийн хэмжээнд арилжааны банкинд байршиж буй нийт 26 дансаар гүйлгээ хийгдэж, хамтран гэрээний хэрэгжилтийг 100 хувь ханган хамтран ажиллаж, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна. | | |
| 12. | Арга хэмжээ 2.1.15. Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн | Нийгмийн даатгалын сангийн тайланг шинэ хэрэгжэж байгаа sicos программ дээр анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж хэвшээд байна. 2024 оны сангийн тайлангаар гарсан өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан хяналт тавихаас гадна Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазад хаалт хийлгэх ажлыг тогтоосон хугацаанд ажлыг зохион байгуулсан болно. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сан бүрдүүлсэн байна. | | | |
| 13. | Арга хэмжээ 2.1.16. Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг НДЕГ-ын СБГ-ын нягтлангуудтай хамтран "Core" системээр бүртгэл хөтлөх бэлтгэл ажлыг хангаан анхны туршилтуудыг хамтран явууллаа.<br>Уг ажлын хүрээнд нийт байцаагч, ажилтнуудын эрхийн бүлгийг тохируулан, нэвтрэх эрхийг өгч, тэдний үндсэн мэдээллийг оруулах программын өөрчлөлт бүхэн дээр цаг тухайд нь нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 14. | Арга хэмжээ 2.1.17. Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн | а) Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хамтарсан "Маягт, журам батлах тухай" 246/A/245 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт /З-НД, Б-НД/"-ыг мөн тушаалын 4-р дугаар хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | маягт хөтлөх журам"-ын дагуу нийгмийн даатгалын санхүүгийн үйл ажиллагаа бүртгэгдэн явагдаж байна.<br><br>б) Нийгмийн даатгалын сангийн тайлангаар сангийн болон байгууллагын тайлангаар гарсан өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан хяналт тавин ажиллаж байна. | | |
| 15. | Арга хэмжээ 2.1.18. ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. | а) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч | Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсаны дагуу 3903,3303 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т хүргүүлж 2024 оны хагас жилийн байдлаар ЭМДЕГазартай өглөг авлага байхгүй тооцоо нийлж хүлээлгэн өгсөн. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна.<br>в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т ирүүлнэ. | | | |
| **3. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт”** | | | | | | | |
| 16. | Арга хэмжээ 3.1.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 159 мэдээллийг 2023 оны байдлаар 100 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. 100 хувь байршуулна. | 2024 оны үйл ажиллагааны зардлын 51 төрлийн, нийгмийн даатгалын сангийн 129 төрлийн мэдээллийг байгууллагын нягтлан бодогч, сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнгүүд https://info.shilendans.gov.mn сайтад сар, улирал, жилээр мэдээллийг байршуулж ахлах нягтлан бодогч болон газрын даргын тушаалаар хяналт шалгалтын байцаагч байнгын хяналт тавин ажиллаж байна. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдлаар 167 мэдээллийг Shilendans. gov.mn цахим хуудсанд байршуулна. | | | | | |
| **4. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.** | | | | | | | |
| 17. | Арга хэмжээ 4.1.2 ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 100 %-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулан ажиллана. | Тус хэлтэс нь тайлант хугацаанд ажил олгогч, даатгуулагч, иргэдээс нийтдээ 127 албан бичиг, өргөдлийг хүлээн авч 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 18. | Арга хэмжээ 4.1.6 Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ- | Монгол Улсын Засаг захиргаа , нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67-дугаар зүйлийн 67.5 дахь заалт, хэлтсийн Хөдөлмөрийн дотоод журмын 11,3 дахь заалт , газрын даргын тушаалыг үндэслэн 12 ажилтанд нийт 7,624.30 төгрөгийн мөнгөн тусламж олгосон. Монгол Улсын Засаг захиргаа , нутаг дэвсгэрийн | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ын Тамгын газарт тайлагнасан байна. | нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67- дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт , Ахмад настаны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт , газрын даргын тушаалыг үндэслэн монгол уламжлалт цагаан сарын баярыг тохиолдуулан тус газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 22 ажилтанд 75000 төгрөг , 1 ажилтанд 50000 төгрөг нийт 1.700.000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон. 2024 оны жилийн байдлаар 9.324.30 мянган төгрөгийн тэтгэмж олгосон. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Арга хэмжээ 1. Монгол бичгээр уншиж, бичих чадвар эзэмших | Уншиж, бичдэг болсон байх | Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын хүрээнд: 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулахад бэлтгэгдсэн байна. | Монгол бичгээр уншиж сурсан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 2 | Арга хэмжээ 2.Гадаад оронд нийгмийн даатгалын байгууллагын туршлага судлах сургалт. | Тухайн орны нийгмийн даатгалын үйл ажиллагааг харьцуулан судлах. | Мэдлэг туршлага судалсан байх. | Сурсан мэдсэн туршлагаа өөрийн ажилдаа хэрэгжүүлэх. | БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Хөх хотод хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон нийгмийн даатгалын талаар үйл ажиллагааг судаллаа. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч ............................................ / С.Отгонцэцэг / ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

# НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br><br>Нийгмийн даатгалын сан болон байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийн саналыг НДЕГ-т ирүүлэх | Чанар, хугацаанд нь хийж хүргүүлсэн байх. | Нийгмийн даатгалын сангийн 2025-2026 оны төсвийн төсөл, төсөөллийг хугацаанд нь хүргүүлсэн. | Сангийн болон байгууллагын зардлын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийн саналыг чанартай хийж хугацаанд нь хүргүүлсэн байх | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024 оны А/72 дугаар тушаал , БГД нийгмийн даатгалын газрын даргын А/05 тушаалыг үндэслэн сан болон байгууллагын урсгал зардлын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийн саналыг хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна. | 2024.05.28<br>-<br>2024.06.20 | 100% |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.<br>Ажлын цаг ашиглалт, хувцаслалт, бүтээмжийг дээшлүүлж нийтийг хамарсан ажилд бүрэн, идэвхтэй оролцсон байдал, зохион байгуулах. | Эрүүл монгол хүн-эко аяллын өдөрлөг" спорт явган өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулах, албан хаагчдаа хувцаслалт жигдрүүлэх, олон нийтийн ажилд хамт олны оролцуулах | Хамт олон амжилттай оролцсон байх. | Хамт олон багаар ажиллах чадвар нэмэгдсэн байна, стандарт хувцсаар жигдэрсэн байна. | Хэлтэс нь ажлын цаг ашиглалт бүрэн, хувцаслалтаараа жигдэрч, дүүргээс зохион байгуулсан тэмцээн, НДЕГ-с зохион байгуулсан "Эрүүл монгол хүн-эко аяллын өдөрлөг" спорт явган аялал, хэлтсүүдийн хоорондын сагсан бөмбөгийн тэмцээнд хамт олноо зохион байгуулж, мөн салбарын бүх ажилтны дунд зохион байгуулсан команд штабын сургуулилалтад амжилттай оролцоо. | 2024.05.01<br>-<br>2024.12.31 | 100% |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

| | | |
|---|---|---|
| САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН ДАРГА БӨГӨӨД АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ | .............................. / С.ОТГОНЦЭЦЭГ/ | ......... ......... ......... |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

| | | |
|---|---|---|
| ДАРГА | .............................. / Л.ОЧИРБАЛ / | ......... ......... ......... |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |